

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/305/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ СУМЫН ХҮҮХДИЙН  
ЦЭЦЭРЛЭГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секьюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: [rsamongolia@gmail.com](mailto:rsamongolia@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал .....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 9/180.  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Г.МЯНДАССАЙХАН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 8 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 79,3 хувиар хэрэгжүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт дунд

### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

019020422

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>69,851,537.04</b>	<b>109,814,800.14</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	46,782,296.84	86,648,716.14
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	46,782,296.84	86,648,716.14
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	46,782,296.84	86,648,716.14
31211	Төрийн сангийн харилцах	46,782,296.84	86,648,716.14
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	23,069,240.20	23,166,084.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	3,761,832.00	3,817,800.00
35110	Тусгай зориулалттай материал	3,761,832.00	3,817,800.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	19,307,408.20	19,348,284.00
35410	Бичиг хэргийн материал	2,587,500.00	2,737,500.00
35420	Аж ахуйн материал	11,605,221.00	11,687,254.00
35460	Хүнсний материал	3,177,907.20	3,459,710.00
35470	Бусад хангамжийн материал	1,936,780.00	1,463,820.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>853,568,817.39</b>	<b>853,329,148.38</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	853,568,817.39	853,329,148.38
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	833,568,817.39	833,329,148.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	836,479,822.95	836,479,822.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	-39,630,305.43	-56,031,103.59
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	37,886,643.00	60,892,043.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-18,578,811.42	-22,957,687.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,001,593.76	26,001,593.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,117,625.47	-14,583,020.69
39217	Ном	3,527,500.00	3,527,500.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	20,000,000.00	20,000,000.00
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>923,420,354.43</b>	<b>963,143,948.52</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>256,850.00</b>	<b>498,850.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	256,850.00	498,850.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	256,850.00	498,850.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	256,850.00	495,850.00
41361	Байгууллагад төлөх өглөг	256,850.00	256,850.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	239,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>923,163,504.43</b>	<b>962,645,098.52</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	923,163,504.43	962,645,098.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	77,704,995.45	77,704,995.45
51101	Өмч: - төрийн	77,704,995.45	77,704,995.45
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	811,765,338.95	851,246,933.04
51210	Өмнөх үеийн үр дүн	811,765,338.95	811,765,338.95
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	39,481,594.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	33,693,170.03	33,693,170.03
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>923,420,354.43</b>	<b>963,143,948.52</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>291,028,550.00</b>	<b>329,337,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,494,550.00</b>	<b>22,700,400.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,494,550.00	22,700,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,494,550.00	22,700,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,500.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,391,050.00	22,700,400.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>283,534,000.00</b>	<b>306,637,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	231,543,800.00	267,648,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	231,543,800.00	267,648,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	10,805,300.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,805,300.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	41,184,900.00	38,988,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,184,900.00	38,988,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>263,180,638.81</b>	<b>289,856,105.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>263,180,638.81</b>	<b>289,856,105.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	246,348,952.61	284,522,543.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	139,092,143.28	170,101,203.23
210101	Үндсэн цалин	110,619,803.62	131,458,514.10
210102	Нэмэгдэл	23,174,706.96	31,445,823.20
210104	Урамшуулал	5,297,632.70	7,196,865.93
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17,378,878.68	20,948,377.47
210201	Тэтгэврийн даатгал	17,378,878.68	20,948,377.47
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,016,495.00	33,155,137.92
210301	Гэрэл, цахилгаан	1,720,815.00	2,208,225.92
210302	Түлш, халаалт	23,157,680.00	30,876,912.00
210303	Цэвэр, бохир ус	138,000.00	70,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	00.00	4,304,209.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	4,304,209.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	25,886,176.06	24,461,097.20
210502	Хоол, хүнс	25,886,176.06	24,461,097.20
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500,000.00	00.00
210604	Урсгал засвар	500,000.00	00.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	108,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	108,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	592,000.00	556,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	556,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	37,775,259.59	30,996,519.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,803,667.00	7,751,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	556,800.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,414,792.59	23,245,069.01
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	16,831,686.20	5,333,562.08

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10,701,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	10,701,800.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	6,129,886.20	5,333,562.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,129,886.20	5,333,562.08
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>27,847,911.19</b>	<b>39,481,594.09</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>283,637,500.00</b>	<b>306,637,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>103,500.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	103,500.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	103,500.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,500.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>283,534,000.00</b>	<b>306,637,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	231,543,800.00	267,648,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	231,543,800.00	267,648,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	10,805,300.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,805,300.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	41,184,900.00	38,988,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,184,900.00	38,988,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>236,900,203.16</b>	<b>266,465,880.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>236,900,203.16</b>	<b>266,465,880.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>220,068,516.96</b>	<b>261,132,318.62</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	140,686,171.54	169,884,036.87
210101	Үндсэн цалин	111,512,331.95	131,458,514.10
210102	Нэмэгдэл	23,166,706.89	31,228,656.84
210104	Урамшуулал	6,007,132.70	7,196,865.93
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	15,784,850.42	21,162,543.83
210201	Тэтгэврийн даатгал	10,772,587.12	14,408,377.04
210202	Тэтгэмжийн даатгал	1,267,362.05	1,695,091.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,013,889.65	1,355,733.12
210204	Ажилгүйдлийн даатгал	248,273.73	330,672.90
210205	Эрүүл мэндийн даатгал	2,482,737.87	3,372,669.38
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,052,495.00	33,155,137.92
210301	Гэрэл, цахилгаан	4,615,525.00	2,208,225.92
210302	Түлш, халаалт	20,262,970.00	30,876,912.00
210303	Цэвэр, бохир ус	174,000.00	70,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	26,565,000.00	24,646,250.00
210502	Хоол, хүнс	26,565,000.00	24,646,250.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	592,000.00	556,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	556,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,888,000.00</b>	<b>11,228,350.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,388,000.00	9,721,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500,000.00	1,506,550.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,831,686.20</b>	<b>5,333,562.08</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>10,701,800.00</b>	<b>00.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	10,701,800.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,129,886.20</b>	<b>5,333,562.08</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,129,886.20	5,333,562.08
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>46,737,296.84</b>	<b>40,171,419.30</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>305,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>305,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>305,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	305,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-305,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>46,737,296.84</b>	<b>39,866,419.30</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>45,000.00</b>	<b>46,782,296.84</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>46,782,296.84</b>	<b>86,648,716.14</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,704,995.45	33,693,170.03	811,765,338.95	923,163,504.43
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,704,995.45	33,693,170.03	811,765,338.95	923,163,504.43
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	77,704,995.45	33,693,170.03	811,765,338.95	923,163,504.43
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	39,481,594.09	39,481,594.09
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,704,995.45	33,693,170.03	851,246,933.04	962,645,098.52

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангил	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>353,419,600.0</b>	<b>266,770,880.7</b>	<b>86,648,719.3</b>	<b>75.48</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>353,419,600.0</b>	<b>266,770,880.7</b>	<b>86,648,719.3</b>	<b>75.48</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>353,419,600.0</b>	<b>261,437,318.6</b>	<b>91,982,281.4</b>	<b>73.97</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>243,111,200.0</b>	<b>169,884,036.9</b>	<b>73,227,163.1</b>	<b>69.88</b>
2E+05	Үндсэн цалин	160,992,600.0	131,458,514.1	29,534,085.9	81.66
2E+05	Нэмэгдэл	76,247,200.0	31,228,656.8	45,018,543.2	40.96
2E+05	Урамшуулал	5,871,400.0	7,196,865.9	(1,325,465.9)	122.6
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,084,600.0</b>	<b>21,162,543.8</b>	<b>8,922,056.2</b>	<b>70.34</b>

2E+05	Тэтгэврийн даатгал	20,457,900.0	14,408,377.0	6,049,523.0	70.43
2E+05	Тэтгэмжийн даатгал	2,406,700.0	1,695,091.4	711,608.6	70.43
2E+05	ҮОМШӨ-ний даатгал	1,925,700.0	1,355,733.1	569,966.9	70.40
2E+05	Ажилгүйдлийн даатгал	481,200.0	330,672.9	150,527.1	68.72
2E+05	Эрүүл мэндийн даатгал	4,813,100.0	3,372,669.4	1,440,430.6	70.07
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,488,700.0</b>	<b>33,155,137.9</b>	<b>5,333,562.1</b>	<b>86.14</b>
2E+05	Гэрэл, цахилгаан	4,074,300.0	2,208,225.9	1,866,074.1	54.20
2E+05	Түлш, халаалт	34,214,400.0	30,876,912.0	3,337,488.0	90.25
2E+05	Цэвэр, бохир ус	200,000.0	70,000.0	130,000.0	35.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>28,963,500.0</b>	<b>24,646,250.0</b>	<b>4,317,250.0</b>	<b>85.09</b>
2E+05	Хоол, хүнс	28,963,500.0	24,646,250.0	4,317,250.0	85.09
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.0</b>	<b>500,000.0</b>	<b>-</b>	<b>100</b>
2E+05	Урсгал засвар	500,000.0	500,000.0	-	100
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>561,200.0</b>	<b>556,000.0</b>	<b>5,200.0</b>	<b>99.07</b>
2E+05	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	561,200.0	556,000.0	5,200.0	99.07
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,710,400.0</b>	<b>11,533,350.0</b>	<b>177,050.0</b>	<b>98.49</b>
2E+05	Бараа үйлчилгээний бусад зардал	10,026,800.0	10,026,800.0	-	100.00
2E+05	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,683,600.0	1,506,550.0	177,050.0	89.48
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,333,562.1</b>	<b>5,333,562.1</b>	<b>-</b>	<b>100</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>5,333,562.1</b>	<b>(5,333,562.1)</b>	
2E+05	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	5,333,562.1	(5,333,562.1)	
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>306,637,300.0</b>	<b>306,637,300.0</b>	<b>-</b>	<b>100</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>267,648,600.0</b>	<b>267,648,600.0</b>	<b>-</b>	<b>100</b>
1E+05	Улсын төсвөөс санхүүжих	267,648,600.0	267,648,600.0	-	100
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>38,988,700.0</b>	<b>38,988,700.0</b>	<b>-</b>	<b>100</b>
1E+05	Орон нутгийн төсвөөс	38,988,700.0	38,988,700.0	-	100
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>46,782,296.8</b>	<b>(46,782,296.8)</b>	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>86,648,716.1</b>	<b>(86,648,716.1)</b>	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдийг бие бялдар оюун ухаан нийгэмшихүй хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын цэцэрлэг нь 2023 оныг "Цэцэрлэгийн багшийн хөгжлийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 8 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 79,3 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус цэцэрлэг нь 12 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 оны 11 сард аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдсан. 89,7 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын цэцэрлэгийн 2023. оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39,723.6 мянган төгрөгөөр буюу 4,1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	69,851.5	109,814.8	39,963.3
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	23,069.2	23,166.0	96.8
Үндсэн хөрөнгө	853,568.8	853,329.1	-239.7
Нийт хөрөнгө	<b>923,420.3</b>	<b>963,143.9</b>	<b>39,723.6</b>
Өр төлбөр	256.8	498.8	242.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	923,163.5	962,645.0	39,481.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<b>923,420.3</b>	<b>963,143.9</b>	<b>39,723.6</b>

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 39,963.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь урд оны төсвийн гүйцэтгэлийн үлдэгдэл, мөнгөн хөрөнгө дансанд орж ирснээс шалтгаалан мөнгө данс өссөн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 96.8 мянган төгрөгөөр өссөн нь материалын үнэ өссөнтэй холбоотой байна. Мөн цэцэрлэгийн эрхлэгчийн 2023 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн А/11 тоот тушаалаар бусад хангамжийн материал 821.3 мянган төгрөг, тусгай зориулалтын материал 479.7 мянган төгрөг, аж ахуйн материал 3,003.1 мянган төгрөг нийт 4,304.1 мянган төгрөгийн бараа материалыг акталсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 239.7 мянган төгрөгөөр буурсан нь элэгдэлтэй холбоотой.

Өглөг данс 242.0 мянган төгрөгөөр өссөн нь харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дүн дутуу байсантай холбоотой.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 313,430.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 38,988,7 мянган төгрөг нийт зарлагыг 353,419.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 353,419.6 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 353,419.6 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 313,430.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 38,988.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 266,770.8 мянган төгрөг буюу 75,5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 86,648.7 мянган төгрөгөөр, үүнээс үндсэн цалинг 29,534.0 мянган төгрөгөөр, нэмэгдэл цалинг 45,018.5 мянган төгрөгөөр, хоол хүнс 4,317.2 мянган төгрөгөөр, бүх төрлийн даатгалын зардлаас 8,922.0 тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Мөн урамшууллын 1,325.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	71801-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605-Эрүүл мэндийг дэмжих	841.8	841.8		100%
2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	28,963.5	24,646.2	4.317.2	85,1%
3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,486.6	2,486.6		100%
4	81823-Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	841.8	841.8		100%
5	81833 Явуулын багшийн үйлчилгээ	4,895.9	3,269.9	1625.9	66,8%

6	81834 Боловсролын стандарт	207,503.5	144,574.4	62,929.1	69,7%
7	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	68,898.0	51,121.5	17,776.4	74,2%
8	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	38,998.7	38,988.7		100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын төвийн цэцэрлэг нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71801-81605	2023-12-31	Эрүүл мэндийг дэмжих	58%	2,138.7	1,240.0
2	71801-81807	2023-12-31	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	85,8%	92,591.4	79,464.9
3	71801-81816	2023-12-31	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	100%	5,028.0	5,028.0
4	71801-81823	2023-12-31	Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	98,7%	2,166.7	2,138.7
5	71801-81833	2023-12-31	Явуулын багшийн үйлчилгээ	80,5%	4,238.9	3,446.7
6	71801-81834	2023-12-31	Боловсролын стандарт	87,2%	471,034.7	410,863.1
7	71801-81835	2023-12-31	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	89%	165,289.7	147,179.0
8	71801-80111	2023-12-31	Тогтмол зардал	89,9%	93,061.8	83,696.2

Цэцэрлэгийн хүүхдийн хоол арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь сургуулийн хүүхдийн улирлын амралттай холбоотойгоор хүүхдийн ирц багасдагтай холбоотойгоор хэмнэгдсэн. Явуулын багшийн үйлчилгээ арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь орон тоо хэмнэсэн, хүүхдийн ирцтэй холбоотойгоор хэмнэгдсэн. Эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь хагас ажилчид урьд онд хамрагдсантай холбоотой.

Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь томуу томуу төст өвчин ихэссэн, цахимд шилжсэнтэй холбоотойгоор хүүхдийн ирц буурч хэмнэгдсэн.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Цахим дэлгүүрээс худалдан авалт байхгүй. Бүх худалдан авалтаа Аймгийн боловсролын газраас тендерт шалгарсан байгууллагуудаас шууд худалдан авалт хийдэг. Хүнсний материалыг Баян-Өнжүүл сумын Мөнхтулга ХХК-с худалдан авдаг

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг, “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 225,000,0 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 4,500,0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3,600,0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 3 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласны үр дүнд ажиллагсад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэх 8 төрлийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 73,227.1 мянган төгрөгөөр
- Байр ашиглахтай холбоотой болон эд хогшил худалдан авах зардлыг 5,333.5 мянган төгрөгөөр
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 177.0 мянган төгрөгөөр
- Нормативт зардлыг 4,317.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 151 мэдээллийг байршуулж 9 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3 “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулан зөвлөмж өгөв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн ба өмнөх аудитаар өгсөн алдаа зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 1,700.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах /Шөнийн нэмэгдэл бодож олгоогүйтэй холбоотой/ 1 зөвлөмж өгч ажилласан. Завсрын аудитын зөвлөмжийн биелэлтийг жилийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад зөвлөмж хэрэгжээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
<b>Акт</b>					
<b>Албан шаардлага</b>	2	12,662.3	2	12,662.3	100
<b>Зөвлөмж</b>	1	7,228.3	1	7,228.3	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>19,890.6</b>	<b>3</b>	<b>19,890.6</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,958.5 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 1,459.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 498.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Зардлын данстай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

1,459.7 мянган төгрөгийн хүнсий материал илүү нөөцөлсөн зөрчил илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар бүлэг 6.4.1-д “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төсөвлөж зарцуулах”, 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагагүй бараа материалыг үр ашиггүйгээр удаан хадгалах шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал нөөцлөхгүй” заалтуудыг мэдэгдлийг хангахгүй байна. .

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн үр ашиггүйгээр түргэн муудах бараа материалыг нөөцөлсөн буруутай этгээдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

### 5.3 Зөвлөмж

1.Өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Өглөгийн дансны үлдэгдлийг баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” Төсвийн тухай хуулийн 6,4,8-д” Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх” хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид өр авлага үүсгэхгүй ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хүнсний материал илүү нөөцөлсөн	1	1,459.7	1	1,459.7								
Өглөгийн дансны үлдэгдлийг баталгаажуулаагүй	1	498.8					1	498.8				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,958.5</b>					<b>1</b>	<b>498.8</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)